

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын-ны өдөр

Улаанбаатар хот

ХОТЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын нийслэл болон улсын зэрэглэл, аймгийн зэрэглэл тогтоосон хотод хотын албан татвар ногдуулах, уг татварыг төсөвт төвлөрүүлэх, тайлагнахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Хотын албан татварын тухай хууль тогтоомж

2.1.Хотын албан татварын тухай хууль тогтоомж нь Төсвийн тухай хууль, Татварын ерөнхий хууль, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Хотын нутаг дэвсгэрт энэ хуулийн 4.1.3 заасан барааг худалдан авсан этгээд, энэ хуулийн 4.1.4-4.1.7-д заасан үйлчилгээг авсан этгээдэд хотын албан татвар ногдуулахад энэ хууль үйлчилнэ.

4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“хотын албан татвар суутгагч” гэж энэ хуулийн 4.1.3-т заасан бараа борлуулсан этгээд, 4.1.4, 4.1.5, 4.1.6, 4.1.7, 4.1.8, 4.1.9-д заасан үйлчилгээ үзүүлсэн этгээдийг;

4.1.2.“хот” гэж Монгол Улсын Үндсэн хуулийн 13 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар Монгол Улсын нийслэл, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан аймгийн зэрэглэл тогтоосон хот, 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан улсын зэрэглэл тогтоосон хотыг;

4.1.3.“бараа” гэж жижиглэнгийн худалдаагаар борлуулсан бүх төрлийн согтууруулах ундаа, тамхийг;

4.1.4 “зочид буудал” гэж үйлчлүүлэгчийг хүлээн авч байр, хоолны болон бусад үйлчилгээ үзүүлдэг, нэмэлт тоноглол, тусгай төрөлжсөн албад бүхий цогцолборыг;

4.1.5.“амралтын газар” гэж тав тухтай амрах, зугаалах нөхцөлийг бүрдүүлсэн байр, хоолны үйлчилгээ үзүүлэх байгууламжийг;

4.1.6.“ресторан” гэж үйлдвэрлэлийн нарийн ажиллагаа шаарддаг олон нэр төрлийн хоол ундаа, түүний дотор нэршсэн болон захиалгат хоолыг

технологийн өндөр түвшинд үйлдвэрлэж, хэрэглэгчийн тав тухтай хооллох нөхцөлийг хангасан дээд зэргийн үйлчилгээг зохион байгуулдаг хоолны газрыг;

4.1.7. “баар” гэж хөгжим, гэрэлтүүлэг болон тусгай зориулалтын бусад төхөөрөмжөөр тоноглогдсон, үйлчлүүлэгчийн амралт, чөлөөт цагийг тав тухтай өнгөрүүлэхэд зориулагдсан, төрөл бүрийн ундаа, хөнгөн зууш, амттанаар үйлчилдэг үйлчилгээний газрыг;

4.1.8. “автомашин угаалгын газар” гэж автомашины бохирдлыг цэвэрлэх иж бүрэн үйлчилгээ үзүүлэх байгууламжийг;

4.1.9. “авто үйлчилгээ үзүүлэгч” гэж нийтийн тээврээс бусад авто тээврийн хэрэгслийн ашиглалттай холбогдсон үйлчилгээг үзүүлэх иргэн, аж ахуйн нэгжийг.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

АЛБАН ТАТВАР ТӨЛӨГЧ, АЛБАН ТАТВАР СУУТГАН ТӨЛӨГЧИЙГ ТОДОРХОЙЛОХ, ТҮҮНИЙГ БҮРТГЭХ, БҮРТГЭЛЭЭС ХАСАХ

5 дугаар зүйл. Хотын албан татвар төлөгч

5.1. Хотын албан татвар суутгагч /цаашид “албан татвар суутгагч” гэх/-аас энэ хуульд заасан бараа, үйлчилгээг худалдан авч байгаа этгээд хотын албан татвар төлөгч байна.

6 дугаар зүйл. Албан татвар суутган төлөгч бүртгэх, бүртгэлээс хасах

6.1. Энэ хуулийн 4.1.1-д заасан этгээдийг улсын бүртгэл, хотын захиргааны болон бусад холбогдох бүртгэл, мэдээллийн байгууллагын мэдээлэлд үндэслэн харьяалах татварын алба албан татвар суутгагчаар бүртгэнэ.

6.2. Татварын алба албан татвар суутгагчийг бүртгэх, бүртгэлээс хасах, мэдээлэл хүлээн авах журмыг хотын засаг дарга, татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга хамтран батална.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

АЛБАН ТАТВАР НОГДОХ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭ

7 дугаар зүйл. Хотын албан татвар ногдох бараа, үйлчилгээ

7.1. Татвар төлөгчийн худалдан авсан дараах бараанд хотын албан татвар ногдуулна:

7.1.1. энэ хуулийн 4.1.3-т заасан бүх төрлийн согтууруулах ундаа;

7.1.2. энэ хуулийн 4.1.3-т заасан бүх төрлийн тамхи.

7.2. Татвар төлөгчийн худалдан авсан дараах үйлчилгээнд хотын албан татвар ногдуулна:

7.2.1. энэ хуулийн 4.1.4-т заасан зочид буудлын үйлчилгээ;

7.2.2. энэ хуулийн 4.1.5-д заасан амралтын газрын үйлчилгээ;

7.2.3. энэ хуулийн 4.1.6-д заасан рестораны үйлчилгээ;

7.2.4. энэ хуулийн 4.1.7-д заасан баарны үйлчилгээ;

7.2.5. энэ хуулийн 4.1.8-д заасан үйлчилгээ;

7.2.6. энэ хуулийн 4.1.9-д заасан үйлчилгээ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

АЛБАН ТАТВАРЫГ НОГДУУЛАХ ЖУРАМ

8 дугаар зүйл. Хотын албан татвар тооцох үнэлгээ

8.1. Хотын албан татвар тооцох үнэлгээг борлуулсан бараа, үзүүлсэн үйлчилгээний үнийн дүнд үндэслэн тооцно.

8.2.Дараах тохиолдолд хотын албан татвар тооцох үнэлгээг харьяалах татварын алба бодит үнэ болон жишиг үнийн аргаар тодорхойлно:

8.2.1.борлуулсан бараа, үзүүлсэн үйлчилгээний үнэ тодорхойгүй;

8.2.2.бараа, үйлчилгээг харилцан солилцсон буюу арилжсан;

8.2.3.харилцан хамаарал бүхий этгээдүүд хоорондоо зах зээлийн бодит үнээс хямд буюу өндөр үнээр бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэн, эсхүл үнэ төлбөргүй шилжүүлсэн;

8.2.4.өр төлбөрийг бараа шилжүүлэх, үйлчилгээ үзүүлэх замаар хаасан.

8.3.Хотын албан татвар тооцох үнэлгээг гадаад валютаар хийсэн бол гүйлгээ хийгдсэн өдрийн Монгол банкны ханшийг үндэслэн төгрөгт шилжүүлнэ.

ТАВДУГААР БҮЛЭГ

АЛБАН ТАТВАРЫН ХУВЬ

9 дүгээр зүйл. Хотын албан татварын хувь

9.1.Татвар төлөгчийн худалдан авсан энэ хуулийн 7.1, 7.2-т заасан бараа, үйлчилгээнд энэ хуулийн 8.1-д заасан үнийн дүнг үндэслэн энэ хуулийн 9.2-т заасан хувиар тооцож хотын албан татвар ногдуулна.

9.2.Хотын албан татварын хувийг байршил, хүн амын төвлөрлийг харгалзан, 0-2.0 хувийн хязгаарт багтаан нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, улсын зэрэглэл болон аймгийн зэрэглэл тогтоосон хотын харьяалах засаг захиргааны нэгжийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тус тус батална.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ

АЛБАН ТАТВАРЫН ЧӨЛӨӨЛӨХ

10 дугаар зүйл. Хотын албан татвараас чөлөөлөх

10.1.Энэ хуулийн 7.2-т зааснаас бусад үйлчилгээг хотын албан татвараас чөлөөлнө.

ДОЛООДУГААР БҮЛЭГ

АЛБАН ТАТВАРЫГ ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛЭХ, ТАЙЛАГНАХ

11 дүгээр зүйл. Хотын албан татвар ногдуулах, түүнийг төсөвт төлөх, тайлагнах

11.1.Албан татвар суутгагч нь хотын албан татварыг бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд суутган авч, төлбөрийн баримт дээр хотын албан татварын хувь, хэмжээг тусгана.

11.2.Албан татвар суутгагч тухайн сард борлуулсан бараа, үзүүлсэн үйлчилгээнд ногдох албан татварыг дараа сарын 10-ны өдрийн дотор төсөвт төлж, тайланг батлагдсан маягтын дагуу дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор харьяалах татварын албанд тушаана.

11.3.Албан татвар суутгагч нь хотын албан татварыг ногдуулахдаа борлуулсан бараа, үзүүлсэн үйлчилгээний үнийн дүнд бусад албан татвар, төлбөр, хураамжийг оруулан тооцохгүй.

11.4.Хотын албан татвар ногдуулах, төлөх, тайлагнах аргачлал, тайлангийн маягтыг татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.

НАЙМДУГААР БҮЛЭГ

БУСАД

12 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

12.1.Энэ хуулийг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын-ны өдөр

Улаанбаатар хот

ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Төсвийн тухай хуулийн дараах заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

1/23 дугаар зүйлийн 23.6.1 заалт:

23.6.1.хотын албан татвар

2 дугаар зүйл. Энэ хуулийг Хотын албан татварын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхэлж дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын-ны өдөр

Улаанбаатар хот

**ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Татварын ерөнхий хуулийн дараах заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

1/7 дугаар зүйлийн 7.2.20 заалт:

7.2.20.хотын албан татвар

2 дугаар зүйл. Энэ хуулийг Хотын албан татварын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхэлж дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын-ны өдөр

Улаанбаатар хот

**НИЙСЛЭЛ ХОТЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛИЙГ
ХҮЧИНГҮЙ БОЛГОХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. 2015 оны 6 дугаар сарын 19-ны өдөр баталсан Нийслэл хотын албан татварын тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Хотын албан татварын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхэлж дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Хотын албан татварын тухай хуулийн төсөлд зааснаар 2 төрлийн бараа борлуулсан, 4 төрлийн үйлчилгээ үзүүлсэн этгээдийг албан татвар суутган төлөгчөөр бүртгэх хуулийн зохицуулалттай.

Нийслэл хотын албан татварын тухай хуулийг хэрэгжүүлэх явцад үүсдэг дараах зөрчлийг шийдвэрлэхээр Аж ахуйн үйл ажиллагааны тухай хуульд нэмэлт оруулах шаардлага үүсэж байна.

Үүнд:

1. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд заасан үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлгүйгээр явуулах;
2. Тусгай зөвшөөрлийг бусдад шилжүүлж, ашиглуулдаг;
3. Тусгай зөвшөөрөлгүй этгээдээс нийслэл хотын албан татвар ногдох бараа борлуулж, үйлчилгээ үзүүлсэн тохиолдолд албан татвар суутган төлөгчөөр бүртгэх үндэслэл байхгүй, хууль зөрчиж олсон орлогыг улсын орлого болгох, хуулийн хариуцлага сул;
4. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн бүртгэлийн мэдээллийг татварын албанд тухай бүр ирүүлдэггүй, албан татвар суутган төлөгчийн бүртгэл, өөрчлөлтийн мэдээллийг шинэчилдэггүй.

Дээрх харилцааг зохицуулснаар татвар төлөгчийн бүртгэл, төсвийн татварын орлогын суурь нэмэгдэх, хууль зөрчсөн этгээдийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох зэрэг ач холбогдолтой.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын-ны өдөр

Улаанбаатар хот

АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 11.1.9 дахь заалт нэмсүгэй:

11.1.9. татварын өргүй байх;

11.1.10. Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлд заасан цахим төлбөрийн баримтын системд холбогдсон байх.

2 дугаар зүйл. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 12 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 12.7 дахь хэсэг нэмсүгэй:

12.7. Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага нь иргэн, хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгосон, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон тухай мэдээлэл, гаргасан шийдвэрийн хуулбарыг шийдвэр гарснаас хойш ажлын 7 хоногийн дотор татварын албанд хүргүүлнэ.

3 дугаар зүйл. Энэ хуулийг 20... оны ... дүгээр сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

